



**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**САЙНШАНД ДЭД СТАНЦЫН 10 КВ-ЫН ХХБ-ЫН БАРИЛГЫН ДОТОР,
ДЭЭВЭР ЗАСВАРЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: *“Сайншанд дэд станцын 10 кВ-ын ХХБ-ын барилгын дотор, дээвэр засварлах”*

Тендерийн дугаар: **ЦДҮС/202001017**

**Багануур дүүрэг
2020 он**

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Зүүн өмнөд бүсийн салбар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Сайншанд дэд станцын 10 кВ-ын ХХБ-ын барилгын дотор, дээвэр засварлах”** ажил гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **30,000** /гучин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 10:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Багануур дүүрэг “ЦДҮС” ТӨХК-ийн Зүүн өмнөд бүсийн салбарын төв байр 3 дугаар давхар 307 тоотод 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 10:20 цагт тендерийг нээнэ.

*Улаанбаатар хот, Багануур дүүрэг “ЦДҮС” ТӨХК-ийн
Зүүн өмнөд бүсийн салбарын төв байр
Утас:7021 3034, 99011755*

Нэг. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй
байх
хугацаа**

**6. Алдааг
залруулах**

- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

**7. Санал
болгосон
үнэ,
түүнийг
үнэлэх**

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал маягтын дагуу ирүүлэх 2. Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулж ирүүлнэ/ 3. Татварын тодорхойлолт; 4. Нийгмийн даатгалын тодорхойлолт; 5. Барилгын угсралтын ажлын БА-2.1, БА-8.1-ийн аль нэг тусгай зөвшөөрөлтэй байх /нотариатаар баталгаажуулах/ 6. Сүүлийн нэг жилийн буюу 2019 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; 7. Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг харуулсан жагсаалт ирүүлнэ. /сүүлийн 2 жил/ 8. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаархи мэдээлэл ирүүлнэ. /сүүлийн 2 жил / 9. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн талаар /гэрээний хуулбар комиссын актны хуулбар хавсарган ирүүлэх/ 10. Шүүхийн тодорхойлолт 11. Ажил гүйцэтгэх график; 12. Ажилчдын мэргэжлийн ур чадварын тодорхойлолт, туршлагын талаар /голлох мэргэжилтний мэргэжлийн үнэмлэхний хуулбар, Нийгмийн даатгалын гэрчилгээний хуулбар/ Голлох инженер нь барилгын инженер бөгөөд мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх 13. Техникийн тодорхойлолтод заасан ажлын даалгавар, ажлын тоо хэмжээ, техникийн шаардлагын дагуу төсөв ирүүлнэ. Төсвийг Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэж эрх бүхийн төсөвчнөөр баталгаажуулсан байна. 14. Захиалагчын албаны буюу техник хяналтын зардал, зураг төсвийн үнэ, магадлашгүй ажлын зардал, нормчлолын сангийн зардлыг төсөв зохиох зааврын дагуу, татвар хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож ирүүлнэ. 15. Тендерт оролцогч нь санал болгож буй үнийн дүнд багтаан тухайн ажлыг стандартын дагуу чанартай хийж дуусган хүлээлгэн өгөх, чанарын баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. 16. Засалын материалын чанарын тодорхойлолт, барааны танилцуулга ирүүлнэ. 17. Тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн жагсаалт ирүүлнэ. 18. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга; 19. Тендерт оролцогч нь тендерээ PDF форматад шилжүүлж цахим хэлбэрээр эмх цэгцтэй ирүүлнэ. <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах</p>

	<p>ажиллагааны систем www.tender.gov.mn -д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Огноо: Тендерийг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг “ЦДҮС” ТӨХК-ийн Зүүн өмнөд бүсийн салбарын төв байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3-н давхар, 307 тоот</p> <p>Огноо: Тендерийг 2020 оны 03 дугаар сарын 23-ны</p> <p>Цаг: 10 цаг 20 минут.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаараас бүрдэнэ:</p> <p>“Сайншанд дэд станцын 10 кВ-ын ХХБ-ын барилгын дотор, дээвэр засварлах ”</p> <p>ЦДҮС/202001017</p>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1.Байршил	Дорноговь аймаг Сайншанд дэд станцын байр
2. Ажлын цар хэмжээ	Энэхүү гэрээнд Ажлын тоо хэмжээ гэсэн бүлэгт байгаа ажлуудыг хийж гүйцэтгэнэ Үнийн санал маягтын дагуу ирүүлэх
3.Барилгын засварын ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд	<ul style="list-style-type: none"> • Засалын ажил гүйцэтгэхдээ тухайн байранд ажил гүйцэтгэж байгаа ажилчдын ажил үйлчилгээнд ямар нэгэн саад бэрхшээл гаргалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллана • Засварын ажилд хэрэглэгдэх материал, тоног төхөөрөмж нь стандарт, чанарын шаардлага хангасан байна. • ЭПДМ /АНУ/ болон түүнтэй адилтгах сайн чанарын бат бэх мембрам материал ашиглан технологийн дагуу хийж гүйцэтгэх • Ажлыг гүйцэтгэж байх явцад технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг хариуцсан инженерт үзүүлж байх ба ил, далд, ажлын акт үйлдэн, гүйцэтгэлийг фото зургаар баталгаажуулна. • Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана • Ажилд орох бүртээ тухайн дэд станцын ээлжийн инженерт заавал мэдэгдэж ажил эхлүүлнэ. • Гэрээнд тусгагдсан бүх ажлыг гэрээний хугацаанд Монгол улсад мөрдөж буй хууль, тогтоомж, БНБД, стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэнэ. • Засварын ажлыг хийж гүйцэтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хугацаанд нь ашиглалтанд өгөхөөр ажлын талбайн зохион байгуулалтыг хийх шаардлагатай. • Дэд станцын барилгын засварын ажил гүйцэтгэхдээ цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэх үеийн ТАД, ААД болон бусад холбогдох дүрэм журмын мөрдөж ажиллана. • Ажлын явцад өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж эвдэрсэн байгууламжийг засварлаж хэвийн байдалд оруулна. • Галын аюулгүй байдал ханган зохих стандарт , хууль, дүрэм журмыг мөрдөн ажиллана.

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

1. Ерөнхий шаардлага

Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, бусад холбогдох хууль дүрмийг мөрдлөгө болгон ажиллана.

Ажилтнуудын аюулгүй байдлыг бүрэн хангасан байх ба ажилтнууд хамгаалах хэрэгсэлээр бүрэн хангагдсан байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, норм дүрмийг мөрдөж ажиллаагүйгээс гарах эрсдэлийг гүйцэтгэгч компани бүрэн хариуцна.

Ажлын тоо хэмжээнд заасны дагуу ажлыг гүйцэтгэн үе шат бүрт захиалагчийн хяналтын инженерт үзүүлэн фото зургаар баталгаажуулан акт үйлдсэний дараа дараагийн ажил үргэлжлүүлэн хийх зөвшөөрөл авч ажиллана.

Барилгын засварын ажлын явцад гарсан хог хаягдалыг зөөвөрлөн, төвлөрсөн хогийн цэгт хаяна.

Заслын ажилд хэрэглэгдэх замаск, эмульс, будаг зэрэг материалууд нь итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторийн шинжилгээгээр баталгаажсан, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй олон улсын хэмжээнд болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар стандартыг бүрэн хангасан байна. Мөн ажилд хэрэглэгдэх элс, хайрга, цемент зэрэг түүхий эд материалууд нь итгэмжлэгдсэн лаборатороор баталгаажсан ашиглахад хүлээн зөвшөөрөгдсөн түүхий эд материалууд байна.

Ажилд хэрэглэгдэх материалуудыг барилгын талбайд их хэмжээгээр татахаас өмнө дээжийг захиалагчид үзүүлж зөвшилцөх зарчим баримталж ажиллана.

Захиалагчтай зөвшилцөөгүй буруу материал авчирч ажилд ашиглах тохиолдолд түүнээс үүдэн гарах алдагдалыг гүйцэтгэгч хариуцна. Заслын ажил БНБД 31-10-05-г хангасан байна.

Цахилгаан байгууламжид заслын ажлыг гүйцэтгэх явцад тухайн ээлжийн ажилтны зөвшөөрлөөр тухайлсан зааварчилгаа авч ажиллана. Дэд станц цахилгаан байгууламжийн хашаанд дураар сэлгүүцэхгүй ба цахилгаан байгууламжид ажиллах үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллана. Тухайн барилга дотор байгаа цахилгааны тоноглолуудыг бохирдуулахаас хамгаалж шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажиллана.


Засварын ажлын материалыг өөрчлөх тохиолдолд захиалагчид байгууллагад бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

Засалын ажлыг чанартай материалаар чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.

БАТЛАВ.

"ЦДҮС" ТӨХК-ийн ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕР

Б.ДАШДАВАА



**САЙНШАНД ДЭД СТАНЦЫН ДЭЭВРИЙН ЗАСВАР БОЛОН ДОТОР
ЗАСАЛ ХИЙХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТОО ХЭМЖЭЭ**

1. Ерөнхий шаардлага

Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, бусад холбогдох хууль дүрмийг мөрдлөгө болгон ажиллана.

Ажилтнуудын аюулгүй байдлыг бүрэн хангасан байх ба ажилтнууд хамгаалах хэрэгсэлээр бүрэн хангагдсан байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, норм дүрмийг мөрдөж ажиллаагүйгээс гарах эрсдэлийг гүйцэтгэгч компани бүрэн хариуцна.

Цахилгаан байгууламжид мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм журам болон бусад хууль дүрмийн заалтуудаар бүх ажилчид аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдуулна. сургалт зохион байгуулах ажлыг захиалагч компани хариуцана.

Барилгын засварын ажлын явцад гарсан хог хаягдалыг тодорхой хугацаанд захиалагч компани заасан цэгт төвлөрүүлж заасан хугацаанд зөвөөрлөн тухайн орон нутгийн төвлөрсөн хогийн цэгт хаяна.

Ажилд хэрэглэгдэх элс,хайрга,цемент зэрэг түүхий эд материалууд нь итгэмжлэгдсэн лаборатороор баталгаажсан ашиглахад хүлээн зөвшөөрөгдсөн түүхий эд материалууд байна.

Дээврийн хуйлмал материал болон бусад шаардлагатай тоноглолууд нь олон улсын хэмжээнд болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар стандартыг бүрэн хангасан чанарын баталгаатай байна.

Усны хаялагийг чанартай төмрөөр сайтар бэхэлж тогтоосон байна.

Ажлын тоо хэмжээнд заасны дагуу ажлыг гүйцэтгэн үе шат бүрт захиалагчийн хяналтын инженерт үзүүлэн фото зургаар баталгаажуулан акт үйлдсэний дараа дараагийн ажил үргэлжлүүлэн хийх зөвшөөрөл авч ажиллана.

Заслын ажилд хэрэглэгдэх замаск, эмульс, будаг зэрэг материалууд нь итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторийн шинжилгээгээр баталгаажсан, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй олон улсын хэмжээнд болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар стандартыг бүрэн хангасан байна.

Ажилд хэрэглэгдэх материалуудыг барилгын талбайд их хэмжээгээр татахаас өмнө дээжийг захиалагчид үзүүлж зөвшилцөх зарчим баримталж ажиллана. Захиалагчтай зөвшилцөөгүй буруу материал авчирч ажилд ашиглах тохиолдолд түүнээс үүдэн гарах алдагдалыг гүйцэтгэгч хариуцна. Заслын ажил БНБД 31-10-05-г хангасан байна.

Цахилгаан байгууламжид заслын ажлыг гүйцэтгэх явцад тухайн ээлжийн ажилтны зөвшөөрлөөр тухайлсан зааварчилгаа авч ажиллана. Дэд станц цахилгаан байгууламжийн хашаанд дураар сэлгүүцэхгүй ба цахилгаан байгууламжид ажиллах үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллана.

Тухайн барилга дотор байгаа цахилгааны тоноглолуудыг бохирдуулахаас хамгаалж шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажиллана.

Засварын ажлын материалыг өөрчлөх тохиолдолд захиалагчид байгууллагад бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

Засалын ажлыг чанартай материалаар чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ

Жич: Ажлын тоо хэмжээг хавсаргав.

2. Ажлын тоо хэмжээ

ЦД?С Т?ХК 3?БС

Сайншанд 10кВ ХХБ дотор засвар дээвэр

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

ДЭЭВРИЙН АЖИЛ /10КВ ХХБ 388.24М2, ӨРГӨТГӨЛ 76,32М2, ГРАЖ 50.12 М2

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Дээврийн уур , ус тусгаарлах мембран наах	м2	494.68
2	Хуйлмал материалан дээвэр буулгах	м2	295.43
3	Барилгын гадна талын төмөр эдлэлүүд ус зайлуулах хоолойн хамт хийх	м2	76.32
4	Уян битум шинглас дээвэрийг буулгах	м2	255

ЗРУ ДОТОР ЗАСЛЫН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	276.79
2	Дотор хана замаск	м2	165.33
3	Хананы гадаргууг зүлгэж өнгөлөх	м2	165.33
4	Хана эмүльдэх	м2	165.33
5	Хана будах	м2	165.33
6	Тааз эмүльдэх	м2	130
7	Тааз замаскдах	м2	130
8	Халаагуурын тэжээлийн кабель солих	м	200
9	Цахилгаан радиатор суурилуулах	ком	10
10	Хуванцар хоолойг угсрах д-50 мм2	метр	200
11	Led гэрэл угсрах	ш	20
12	Далд угсрах унтраалга тавих	ширхэг	2
13	Залгуур далд тавих	ширхэг	4
14	Гэрэлтүүлэгчийн самбар угсрах	ш	1
15	Утас далд угсрах	м	200

ДИСПЕТЧЕРИЙН ӨРӨӨ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хананы хаалга цонхны углуурга авах, ховилыг задлах	хайрцаг	5
2	Хаалга суулгах	ш	5
3	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	36.2
4	Хаалганд цоож суулгах	ш	5
5	200мм хүртэл өргөн муруй амалгааг өндөр чанартай шавардах	у/м	23.6
6	Дулаалгатай паркетан шал хийх	м2	25
7	Хана будах	м2	50.5
8	Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	50
9	Хана эмүльдэх	м2	50
10	Дотор хана замаск	м2	50
11	Хана өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	м2	50
12	Тааз замаскдах	м2	25
13	Тааз эмүльдэх	м2	25
14	Led гэрэл угсрах /коридор,гал тогоо,амралт,дис-ийн өрөө/	ш	30

АККУМЛЯТОРЫН ӨРӨӨ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	53.75
2	Дотор хана замаск	м2	53.75

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

3	Хана өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	м2	53.75
4	Хана эмульсдэх	м2	53.75
5	Шалыг резинэн будгаар 2 удаа будах	м2	25
6	Цахилгаан агааржуулалт суурилуулах	ком	1

опу

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	106.85
2	Хана өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	м2	106.85
3	Дотор хана замаск	м2	106.85
4	Хана эмульсдэх	м2	106.85
5	Металл вакум цонх хананд суулгах	м2	5.78
6	Хананы хаалга цонхны углуурга авах, ховилыг задлах	хайрцаг	2
7	200мм хүртэл өргөн муруй амалгааг өндөр чанартай шавардах	у/м	7
8	0.4 кВ цахилгааны тоноглон шит суурилуулах	ш	6

ТУРШИЛТ ӨРӨӨ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	55.75
2	Дотор хана замаск	м2	55.75
3	Хана өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	м2	55.75
4	Хана эмульсдэх	м2	55.75
5	Шалыг резинэн будгаар 2 удаа будах	м2	55.75

ӨРГӨТГӨЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	230
2	Дотор хана замаск	м2	230
3	Хана өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	м2	230
4	Хана эмульсдэх	м2	230

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |

Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

9. Зөрчил, гологдол арилгах

9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

10. Зөрчил, гологдол арилгахгүй байх

10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үе шатны ажлын хуваарь

11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.

11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх

12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

13. Алданги

13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
- Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.
- Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэл эс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- ГЕН 2.1** Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: **“Сайншанд дэд станцын 10 кВ-ын ХХБ-ын барилгын дотор, дээвэр засварлах”**
- ЦДҮС/202001017**
- ГЕН 2.1** Ажил нь : **“Сайншанд дэд станцын 10 кВ-ын ХХБ-ын барилгын дотор, дээвэр засварлах”**
- Ажлын талбай нь : **Дорноговь аймаг Сайншанд дэд станц**
- ГЕН 3.1** Төслийн менежер нь: **Ашиглалтын инженер Л.Бямбадорж**
- ГЕН 4.1** Зөвшөөрөл авч ажил эхлэсэн өдрөөр тооцогдоно.
- Ажил эхлэх өдөр *2020 оны дугаар сарын*
- Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр *2020 оны дугаар сарын*
- ГЕН 7.1** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ... хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- ГЕН 9.1** Чанарын баталгаат хугацаа **24** сар байна. Баталгаат хугацаанд гарсан гэмтэлийг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.
Барьцаа хөрөнгө гэрээний нийт үнийн дүнгийн **5 хувь** байх бөгөөд гэрээ дүгнэж акт үйлдсэн өдрөөс хойш 12 сарын дараа төлнө.
- ГЕН 13.1** Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн **0.05%** байна.
- Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн **5%** байна.
- ГЕН 17.1** Гүйцэтгэлийн тайланг гэрээ дүгнэж ажил хүлээлцэхэд гаргаж өгнө.
- ГЕН 19.1** Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын %-иар тооцно.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/
Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____

давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

